



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/175

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн нутаг дэвсгэрт Ковид-19-ийн тохиолдол батлагдсантай холбогдуулан Ховд аймгийн нутаг дэвсгэр, Жаргалант болон бусад сумдаас гарах, орох нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнийг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 22:00 цагаас эхлэн тодорхойгүй хугацаагаар хязгаарласугай.

2. Нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч /Ц. Цогтбаяр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын пост, цэгүүдийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн байгууллагуудын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хоол хүнс, аюулгүй байдлыг хангуулах заавар зөвлөмж өгч ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Ховд хотын захирагч бөгөөд Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/175 Ch  
02 1023